

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠎ᠠᠨᠠᠢ ᠎ᠠᠨᠠᠢ ᠎ᠠᠨᠠᠢ ᠎ᠠᠨᠠᠢ

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.ОКТЯБРЬТУЯА
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнсний материалын үлдэгдлийг төсвийн нэгдсэн тайланд төвлөрүүлэлгүй нөөцөлсөн, анхан шатны баримтын бүрдэл болон татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой авлага, өр төлбөрийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бараа материалын дансны бүртгэл тайлагналтай холбоотой эрсдэлтэй асуудлууд зэрэг зөрчлүүд нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>54,063,761.17</u>	<u>55,381,587.94</u>
33	АВЛАГА	<u>1,402,092.92</u>	<u>1,574,447.56</u>
335	Бусад авлага	<u>1,402,092.92</u>	1,574,447.56
3351	Байгууллагаас авах авлага	1,402,092.92	1,574,447.56
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>52,661,668.25</u>	<u>53,807,140.38</u>
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,573,700.00	2,573,700.00
354	Хангамжийн материал	<u>50,087,968.25</u>	<u>51,233,440.38</u>
35410	Бичиг хэргийн материал	388,800.00	388,800.00
35420	Аж ахуйн материал	544,400.00	1,577,400.00
35440	Түлш, шатах тослох материал	1,361.85	1,361.85
35460	Хүнсний материал	846,405.00	812,905.00
35470	Бусад хангамжийн материал	48,307,001.40	48,452,973.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,755,800,309.38</u>	<u>2,644,996,335.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2,755,800,309.38</u>	<u>2,644,996,335.63</u>
392	Биет хөрөнгө	<u>2,715,364,309.38</u>	<u>2,604,560,335.63</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,554,207,096.00	2,554,207,096.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(223,486,950.14)	(292,736,754.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,951,000.00	11,951,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,951,000.00)	(11,951,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	162,577,411.84	164,077,411.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,050,607.55)	(108,960,321.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,655,719.67	116,655,719.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87,562,170.87)	(98,653,037.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	351,205,789.00	351,205,789.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(113,655,071.52)	(134,965,397.43)
93217	Номын фонд	51,473,092.95	53,729,830.34
393	Биет бус хөрөнгө	<u>40,436,000.00</u>	<u>40,436,000.00</u>
39301	Програм хангамж	775,000.00	775,000.00
39302	Хасагдуулга	(775,000.00)	(775,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,436,000.00	40,436,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,809,864,070.55</u>	<u>2,700,377,923.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,824,956.00</u>	<u>13,195,367.70</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>1,824,956.00</u>	<u>13,195,367.70</u>
413	Өглөг	<u>1,824,956.00</u>	<u>13,195,367.70</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	15,000.00	3,440,063.70
4136	Бусад өглөг	<u>1,809,956.00</u>	<u>9,755,304.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,809,956.00	9,755,304.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,808,039,113.72</u>	<u>2,687,182,555.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>2,808,039,113.72</u>	<u>2,687,182,555.87</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	537,142,948.93	537,142,948.93
51101	Өмч: - төрийн	537,142,948.93	537,142,948.93
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1,947,807,064.79</u>	<u>1,826,950,506.94</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,947,807,064.79	1,947,807,064.79
51220	Тайлант үеийн үр дүн		(120,856,557.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	323,089,100.00	323,089,100.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,809,864,069.72</u>	<u>2,700,377,923.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,219,578,205.61	1,090,363,882.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,954,305.61	6,303,709.52
120	Нийтлэг татварын бус орлого	182,954,305.61	6,303,709.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,954,305.61	6,303,709.52
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	182,954,305.61	6,303,709.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	211,649,900.00	213,868,373.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	824,974,000.00	870,191,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,693,373.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,693,373.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,649,900.00	211,175,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,649,900.00	211,175,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,153,460,712.00	1,211,220,440.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,153,460,712.00	1,211,220,440.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,090,748,599.00	1,144,307,996.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	669,680,431.21	694,892,201.70
210101	Үндсэн цалин	541,221,502.00	514,961,202.51
210102	Нэмэгдэл	97,941,228.21	126,687,027.94
210104	Урамшуулал	30,517,701.00	52,717,971.25
210105	Гэрээт ажлын хөлс		526,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,444,853.70	90,707,591.04
210201	Тэтгэврийн даатгал	56,966,983.28	67,307,158.77
210202	Тэтгэмжийн даатгал	6,640,960.68	6,320,712.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,422,631.34	4,685,932.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,310,387.40	1,222,733.26
210205	Эрүүл мэндийн даатгал	13,103,891.00	11,171,053.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,601,212.00	206,483,355.08
210301	Гэрэл, цахилгаан	10,151,812.00	10,527,705.08
210302	Түлш, халаалт	187,935,000.00	191,441,250.00
210303	Цэвэр, бохир ус	4,514,400.00	4,514,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,469,663.00	8,175,872.96
210401	Бичиг хэрэг	353,500.00	843,873.00
210402	Тээвэр, шатахуун	1,831,963.00	1,471,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,000.00	635,599.96
210404	Ном, хэвлэл	332,800.00	2,039,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		140,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	487,400.00	3,045,400.00
2105	Нормативт зардал	8,370,350.00	14,161,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490,700.00	397,300.00
210502	Хоол, хүнс	7,109,450.00	13,763,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,200.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,994,805.00
210604	Урсгал засвар		4,994,805.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	581,000.00	3,213,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	581,000.00	3,213,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,601,089.09	121,679,811.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,201,650.00	7,119,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,399,439.09	114,560,711.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,712,113.00	66,912,443.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,982,530.00	33,044,500.00

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	890,000.00	1,213,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,092,530.00	31,830,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,680,895.00	33,867,943.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,680,895.00	33,867,943.45
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,048,688.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,048,688.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	66,117,493.61	(120,856,557.85)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	71,520,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	71,520,000.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(71,520,000.00)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(5,402,506.39)	(120,856,557.85)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	496,706,948.93	323,089,191.58	1,893,646,325.92	2,713,442,466.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,706,948.93	323,089,191.58	1,893,646,325.92	2,713,442,466.43
C07	Тайлант үеийн үр дүн	40,436,000.00		(785,498,008.08)	(745,062,008.08)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,142,948.93	323,089,100.00	1,947,807,064.79	2,808,039,113.72
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,142,948.93	323,089,100.00	1,947,807,064.79	2,808,039,113.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,142,948.93	323,089,100.00	1,947,807,064.79	2,808,039,113.72
D08	Тайлант үеийн үр дүн	-		(120,856,557.85)	(120,856,557.85)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,142,948.93	323,089,100.00	1,826,950,506.94	2,687,182,555.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,039,197,600.00	1,084,060,173.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,039,197,600.00	870,191,800.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	870,191,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	870,191,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,039,197,600.00	213,868,373.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	824,974,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,573,700.00	2,693,373.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,573,700.00	2,693,373.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,649,900.00	211,175,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,649,900.00	211,175,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	999,516,705.00	1,082,560,173.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	999,516,705.00	1,082,560,173.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,831,687.00	1,021,823,929.55

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,155,100.00	695,469,740.41
210101	Үндсэн цалин	542,272,966.56	515,538,741.22
210102	Нэмэгдэл	99,062,089.44	126,687,027.94
210104	Урамшуулал	30,820,044.00	52,717,971.25
210105	Гэрээт ажлын хөлс		526,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,019,400.00	87,331,596.10
210201	Тэтгэврийн даатгал	56,801,487.00	63,931,163.83
210202	Тэтгэмжийн даатгал	6,721,600.00	6,320,712.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,708,913.00	4,685,932.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,300.00	1,222,733.26
210205	Эрүүл мэндийн даатгал	13,443,100.00	11,171,053.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,601,212.00	206,174,955.08
210301	Гэрэл, цахилгаан	10,151,812.00	10,527,705.08
210302	Түлш, халаалт	187,935,000.00	191,133,250.00
210303	Цэвэр, бохир ус	4,514,400.00	4,514,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,081,675.00	6,356,772.96
210401	Бичиг хэрэг	353,500.00	843,873.00
210402	Тээвэр, шатахуун	1,831,963.00	1,471,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,502,312.00	635,599.96
210404	Ном, хэвлэл	2,906,500.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		140,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	487,400.00	3,235,300.00
2105	Нормативт зардал	7,341,650.00	15,064,660.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490,700.00	397,300.00
210502	Хоол, хүнс	6,080,750.00	13,634,360.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,200.00	1,033,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,994,805.00
210604	Урсгал засвар		4,994,805.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	581,000.00	3,213,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	581,000.00	3,213,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,051,650.00	3,218,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,051,650.00	3,218,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,685,018.00	60,736,243.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,636,330.00	26,868,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	890,000.00	1,213,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,746,330.00	25,654,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	33,867,943.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		33,867,943.45
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,048,688.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,048,688.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>39,680,895.00</u>	<u>1,500,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,500,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,500,000.00)</u>
---	--	---	------------------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,081,366,800.00	1,053,255,759.62	28,111,040.38	97.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,081,366,800.00	1,053,255,759.62	28,111,040.38	97.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,498,500.00	1,022,539,556.55	31,958,943.45	96.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	724,569,700.00	695,469,740.41	29,625,959.59	95.98
210101	Үндсэн цалин	572,577,500.00	515,538,741.22	57,038,758.78	90.04
210102	Нэмэгдэл	109,469,500.00	126,687,027.94	(17,217,527.94)	115.73
210104	Урамшуулал	42,522,700.00	52,717,971.25	(10,195,271.25)	123.98
210105	Гэрээт ажлын хөлс	-	526,000.00	(526,000.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,041,300.00	87,331,596.10	2,709,703.90	96.99
210201	Тэтгэврийн даатгал	66,261,300.00	63,931,163.83	2,330,136.17	96.48
210202	Тэтгэмжийн даатгал	5,945,000.00	6,120,712.89	(175,712.89)	102.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,756,000.00	4,885,932.85	(129,932.85)	102.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,189,000.00	1,222,733.26	(33,733.26)	102.84
210205	Эрүүл мэндийн даатгал	11,890,000.00	11,171,053.27	718,946.73	93.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,175,000.00	206,174,955.08	44.92	100.00
210301	Гэрэл, цахилгаан	10,177,200.00	10,527,705.08	(350,505.08)	103.44
210302	Түлш, халаалт	191,441,300.00	191,133,250.00	308,050.00	99.84
210303	Цэвэр, бохир ус	4,556,500.00	4,514,000.00	42,500.00	99.07
2104	Хангамж, бараа материалын зардал	6,111,200.00	6,067,799.96	43,400.04	99.29
210401	Бичиг хэрэг	594,600.00	554,900.00	39,700.00	93.32
210402	Тээвэр, шатахуун	1,471,600.00	1,471,600.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	635,600.00	635,599.96	0.04	100.00
210404	Ном, хэвлэл	212,800.00	30,000.00	182,800.00	14.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	343,400.00	140,400.00	203,000.00	40.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,853,200.00	3,235,300.00	(382,100.00)	113.39
2105	Нормативт зардал	15,065,300.00	14,964,660.00	100,640.00	99.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	397,300.00	397,300.00	-	100.00
210502	Хоол, хүнс	13,635,000.00	13,534,360.00	100,640.00	99.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,033,000.00	1,033,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	6,494,805.00	5,195.00	99.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,994,805.00	5,195.00	99.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,817,900.00	2,817,900.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,817,900.00	2,817,900.00	-	100.00

**Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,218,100.00	3,218,100.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,218,100.00	3,218,100.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,868,300.00	30,716,203.07	(3,847,903.07)	114.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,868,300.00	26,968,300.00	(100,000.00)	100.37
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,213,900.00	1,213,900.00	-	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,654,400.00	25,754,400.00	(100,000.00)	100.39
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,747,903.07		
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		3,747,903.07		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,081,577,975.00	1,053,255,759.62	28,322,215.38	97.38
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,081,366,800.00	842,080,759.62	239,286,040.38	77.87
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,081,366,800.00	842,080,759.62	239,286,040.38	77.87
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,175.00	211,175,000.00		
132001	Орон нутгийн төсвөөс	211,175.00	211,175,000.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684,373.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,373.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,373.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	288,973.00	
210401	Бичиг хэрэг	288,973.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,400.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	395,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	684,373.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	684,373.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн хадгалалт ашиглалт, хамгаалалттай холбоотой, нягтлан бодох бүртгэл болон татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 09-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлэхүйц байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 11,534.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,074.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,402.1	1,574.4	172.3
Бараа материал	52,661.7	53,807.1	1,145.4
Үндсэн хөрөнгө	2,755,800.3	2,644,996.3	(110,804.0)
Нийт хөрөнгө	2,809,864.1	2,700,377.9	(109,486.2)
Өр төлбөр	1,824.9	13,195.4	11,370.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,808,039.1	2,687,182.6	(120,856.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,809,864.1	2,700,377.9	(109,486.2)

Авлагын дансны үлдэгдэлд Нийгмийн даатгалаас авах 577.7, ХХОАТ-т өгөх 978.8, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд өгөх 7.9, байгууллагын хамтын санд авах 1 ажилтны 10.0, нийт 1,574.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53,807.1 мянган төгрөг болж, 1,145.4 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамнаас хандиваар ирсэн 4,046.9 мянган төгрөгийн сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, тайлант хугацааны худалдан авалт 54,128.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,644,996.3 мянган төгрөг болж, 110,803.9 мянган төгрөгөөр хасагдсан. Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас хандиваар ирсэн 2,256.7 мянган төгрөгийн, худалдан авсан 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр буурсан байна.

Байгууллагад төлөх өглөгийн дансны эцсийн үлдэгдэлд Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд өгөх 2,009.0, Бор янзага ХХК-д өгөх 136.2, Их өргөө ХХК-д өгөх 100.0, Сүхбаатар аймгийн Төрийн сангийн хүү торгуулийн дансанд өгөх, Ус дулаан ОНӨААТҮГ-т өгөх, Хатанцагаан тал ХХК-д өгөх 321.0, 3 иргэнд өгөх 6,996.4, нийт 10,055.4 төгрөгийн өр төлбөр бүртгэгдсэн байна. Өр төлбөрийн дансны үлдэгдэлд 1 харилцагчид өгөх өглөгийг 300.0 мянган төгрөгөөр сөрөг утгаар тайлагнасан.

Мөн ажиллагсадтай холбоотой өглөг дансны эцсийн үлдэгдэлд ЭМНДХ-т өгөх 3,440.1 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэгдсэн байна. Нийт өглөгийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,090,363.9 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 176,650.6 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 57,759.7 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хоолны зардал байна. Энэ нь сургуулийн хичээл 9 дүгээр сараас жигдэрч танхимаар хичээллэж эхэлсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,081,366.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,081,366.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн 1,081,366.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,081,366.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,081,366.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,081,336.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,081,336.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,053,255.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсрол соёл урлагийн газраас 684.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагатай нөхцөл үүссэн тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 онд нийт 647,889.9 мянган төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 539,010.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг ил тод байршуулаагүй, 61,879.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын Засгийн газрын хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 тогтоолын хэрэгжилтийг шалгахад орон тоо бүтэц нэмээгүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 алдаа зөрчилд тогтоосон 4,920.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг 100.0 хувь хэрэгжүүлж, 3 алдаа зөрчилд хүргүүлсэн 76,090.7 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2 алдаа зөрчилд өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжсэн, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	4,920.8	2	4,920.8	-	-	-
Албан шаардлага	3	76,090.7		-	3	76,090.7	100.0
Зөвлөмж	2	18,141.2	1	3,901.0	1	14,240.2	78.5
Нийт дүн	7	99,152.7	3	8,821.8	4	90,330.9	89.3

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар хөрөнгийн тооллого, бараа материалын бүртгэл, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 949,168.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 274,892.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 812.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,745.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 667,717.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгөв. Хариуцлага тооцуулахтай холбоотой албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

1.1. Мөнгөн гүйлгээний тайланд 31,858.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал тусгана", "14.4.1-д "аж ахуйн бүх ажил гүйлгээ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны зардлын дүнд 31,858.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаж залруулсан.

1.2. Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн 31,858.9 мянган төгрөгийг Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас, санхүүжилт дансанд төвлөрүүлснээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ,, баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2 д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах", "эрх ба үүрэг", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн 31,858.9 мянган төгрөгийг улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг дансанд төвлөрүүлснээр тайлагнаж залруулсан.

1.3. Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны 211,175.0 мянган төгрөгийн санхүүжилтийг гадаад хандив тусламжийн орлогоор бүртгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ,, баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2 д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний

стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах", "эрх ба үүрэг", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны 211,175.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Орон төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт дансанд тайлагнаж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 812.9 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 зүйлийн 7.7-д Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах,,", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна."УСНББОУС 12 бараа материалд тавигдах шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

1. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газарт Төсвийн цагалбарт хугацаанд багтаан ирүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчил дутагдал илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д " ,, , жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ,, , ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.4-д "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.13-д "эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

2. Нийт 7 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 5,745.3 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалт, " үнэн зөв байдал", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Хүнсний материалын 30,749.7 мянган төгрөгийн худалдан авалт болон зарцуулалтыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар", баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", "эрх ба үүрэг", "ангилал" батламж мэдээдлийг хангахгүй байна

1.1.2 Өгсөн зөвлөмж:

Материалын орлого зарлага үүссэн тухай бүр он цагийн дарааллаар, нэр төрөл, тоо хэмжээ бүрээр дэлгэрэнгүй болон хураангуй тайлан бэлтгэн гаргах, холбогдох журнал, тайланд тусгах

1.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 17,799.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, мөн 2019 онд үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,573.7 мянган төгрөгийн түрээсийн номыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд тус тус бүртгэсэн, нийт 20,373.4 мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн заавар"-ын 4.16-д "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг дагаж мөрдөнө", УСНББОУС 12 Бараа материалд тавигдах үндсэн шаардлага, "эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгө бодитоор байгаа эсэхийг тогтоох, Өмч хамгаалах байнгын зөвлөл холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэр гаргах. Үндсэн хөрөнгө бодитоор байгаа нь нотлогдвол эдийн засгийн ангиллын дагуу шилжүүлэн бүртгэх, хөрөнгийн үлдээдлийг санхүүгийн тайланд зөв дүнгээр бүртгэн тайлагнах

1.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд Бичиг хэргийн материалын 388.8 мянган төгрөг, аж ахуйн материалын 544.4 мянган төгрөг, түлш шатах тослох материалын 1.4 мянган төгрөг, нийт 934.6 мянган төгрөгийн эхний болон эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, он дамжин үлдэгдлээр бүртгээгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.3.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын үлдэгдэлд дахин тооллого хийж, холбогдох саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж, шийдвэрлэх

2. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт:

Богино хугацаат өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд өгөх 2,009.0 мянган төгрөг, Бор янзага ХХК-д өгөх 136.2 мянган төгрөг, Их өргөө ХХК-д өгөх 100.0 мянган төгрөг, Сүхбаатар аймгийн Төрийн сангийн хүү торгуулийн дансанд өгөх 184.4 мянган төгрөг, Ус дулаан ОНӨААТҮГ-т өгөх 308.4 мянган төгрөг, Хатанцагаан тал ХХК-д өгөх 321.0 мянган төгрөг, 3 иргэнд өгөх 6,996.4 мянган төгрөг, ЭМНДХ-т өгөх 3,440.1 мянган төгрөг, нийт 13,195.4 мянган төгрөгийн өр төлбөр бүртгээгдсэн байна. Өр төлбөрийн дансны үлдэгдэлд 1 харилцагчид өгөх 300.0 мянган төгрөгийн үлдэгдлийг сөрөг утгаар тайлагнасан. Өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй төсвийг зохистой удирдан ажиллах, үүссэн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж өр төлбөр үүссэнийг нотолсны дараа барагдуулах

2.2.1 Илрүүлэлт:

Авлагын дансны үлдэгдэлд Нийгмийн даатгалаас авах 577.7 мянган төгрөгийн, Татварын хэлтсээс авах 978.8 мянган төгрөгийн, Үйлдвэрчний эвлэлийн холбооноос авах 7.9 мянган төгрөгийн, байгууллагын хамтын сантай холбоотой 1 ажилтнаас авах 10.0 мянган төгрөгийн, нийт 1,574.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж авлага үүсгэхгүй төсвийг зохистой удирдан ажиллах, үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 125 ширхэг 16,470.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн

хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1 “элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон” заалт, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-д тавигдах шаардлага, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 647,889.9 мянган төгрөгийн 32 мэдээллийг ил тод байршуулахаас 539,010.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг ил тод байршуулаагүй, 61,879.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

4.1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаагүй	1	31,858.9	1	31,858.9						
2	Орлого үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлснээр тайлагнасан	1	31,858.9	11	31,858.9						
3	Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг гадаад хандив тусламжийн орлогоор тайлагнасан	1	211,175.0	1	211,175.0						
4	Хоол хүнсний материалыг нөөцөлж, төсөвт төвлөрүүлээгүй байна	1	812.9			1	812.9				
5	Худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.	1	5,745.3					1	5,745.3		
6	2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн цагалбарт хугацаанд багтаан Төрийн аудитын газарт ирүүлээгүй	1	-							1	-
7	Хүнсний материалыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан	1	30,749.7							1	30,749.7
8	Хөрөнгийг зөв ангилан бүртгээгүй	1	20,373.4							1	20,373.4
9	Бараа материалын эхний эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй он дамжсан үлдэгдэлтэй	1	934.5							1	934.5

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

10	Өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	13,195.4							1	13,195.4
11	Авлага үүсгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	1,574.4							1	1,574.4
12	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		12	348,278.5	3	274,892.9	1	812.9	2	5,745.3	6	66,827.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	600,889.9							1	600,889.9
Дүн		1	600,889.9	-	-	-	-	-	-	1	600,889.9
Нийт дүн		13	949,168.4	3	274,892.9	1	812.9	2	5,745.3	7	667,717.3